

## РАДИО ДАВТАМЖ, ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХЯНАЛТЫН ТӨВИЙН

### 2026 оны 1-р улирлын ажлын тайлан

#### Нэг. Албан бичиг шийдвэрлэлт:

Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төв (РДӨНХТ)-д 2026 оны 1-р улиралд нийт 38 албан бичиг ирснээс шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

Харилцан нөлөөллийн албан бичиг нийт 20 ирсэн. Үүний дагуу:

- Улаанбаатар хотод 26 байршилд;
- Хөдөө орон нутагт 23 байршилд хэмжилт, хяналт хийсэн.


Цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүй түвшний хэмжилтийн албан бичиг нийт 8 ирсэн. Үүний дагуу:

- Улаанбаатар хотод 5 байршилд;
- Хөдөө орон нутагт 4 байршилд хэмжилт хийсэн.

2026 оны 1-р улирлын “Цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшний хэмжилтийн тайлан”-тай доорх холбоосоор орж танилцана уу.

<https://www.crc.gov.mn/posts/caxilgaan-soronzon-orny-xund-uzuulex-noloonii-aiuulguin-tuvsnii-xemziltiin-tailan-2026-ony-i-uliral/>

Хүсэлт, мэдэгдэл, бусад төрлийн нийт 10 албан бичиг ирсэн.



1-р улирлын хугацаанд чиг үүргийн дагуу нийт 61 албан тоот боловсруулан гаргаж, холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн. Үүнд:

- Хэмжилтийн тайлан: Харилцан нөлөөлөл болон ЦСО-ны хэмжилт, хяналтын үр дүнг баталгаажуулсан 38 тайлан.
- Албан шаардлага: Радио долгионы тухай хууль, холбогдох стандарт зөрчсөн 8 аж ахуйн нэгжид зөрчил арилгуулах тухай хугацаатай албан шаардлага.
- Мэдэгдэл: Техникийн нөхцөл, стандарт мөрдүүлэх болон урьдчилан сэргийлэх чиглэлээр хүргүүлсэн 8 мэдэгдэл.
- Бусад: Байгууллагуудад хүргүүлсэн хариу бичиг, мэдээлэл болон хамтран ажиллах 7 хүсэлт

Радио давтамжийн зурвасын харилцан нөлөөллийн талаарх мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хорооны [www.crc.gov.mn](http://www.crc.gov.mn) цахим хуудсанд байршуулсан дараах маягтын дагуу холбоосоор орж бөглөж [info@crc.gov.mn](mailto:info@crc.gov.mn) хаягт илгээнэ үү.

Линк: <https://www.crc.gov.mn/radio-davtamzhijn-harilcan-n-l-l-l-shalguulah-huudasneyyлах>  
[хуудас](#)

Нийт бүртгэгдсэн харилцан нөлөөллийн шалтгааны ихэнх хувийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагын сүлжээний чанарыг сайжруулах зорилгоор ашиглаж буй баталгаажуулаагүй үүрэн холбооны сүлжээ өсгөгч төхөөрөмж эзэлж байна.



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

## ҮҮРЭН ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ӨСГӨГЧ ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАХ ЗӨВЛӨМЖ ХУУДАС

Иргэн, хуулийн этгээдийн ашиглаж буй дараах төрлийн баталгаажуулалтад хамрагдаагүй, тохирлын гэрчилгээгүй үүрэн холбооны сүлжээ өсгөгч төхөөрөмж нь өргөн зурвасаар хууль бус дохио өрнүүлэн тусгай зөвшөөрөлтэй үүрэн холбооны радио давтамжийн зурваст радио давтамжийн нөлөөлөл үүсгэж улмаар үүрэн холбооны сүлжээг тасалдуулж, олон нийтийн эрх ашгийг хохироож байна.



### Дараах хуулийн заалтуудыг зөрчиж байна. Үүнд:



#### Радио долгионы тухай хууль

7.1. Нийтийн хэрэглээний радио давтамжийн зурвасыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, иргэн энэ хуулийн дагуу Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авч, бүртгүүлж ашиглана.

8.1. Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиггүй этгээд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглахыг хориглоно.

8.2. Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээд тохирлын баталгаагүй радио тоног төхөөрөмж ашиглахыг хориглоно.

14.1. Дараахь төрлийн радио төхөөрөмж ашиглахад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авахгүй:

14.1.1. бүх төрлийн зурагт радио, радио хүлээн авагч;

14.1.2. эмчилгээ, оношилгооны радио төхөөрөмж;

14.1.3. техникийн шаардлага хангасан, тохирлын гэрчилгээтэй богино зайн радио төхөөрөмж.

**19.2.1. энэ хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд радио төхөөрөмж импортлох, үйлдвэрлэх, худалдахыг сонирхогч этгээд Зохицуулах хороотой радио давтамжийн талаар урьдчилан тохирох;**

### Хуулийн хариуцлага:



#### Зөрчлийн тухай хууль

14.2 дугаар зүйл. Радио долгионы тухай хууль зөрчих

5. Бусад радио холбоо, эсхүл радио төхөөрөмж хэрэглэгчийн ажиллагаанд:

5.1. харилцан нөлөөлөл учруулсан;

5.2. хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан;

5.3. баталгаажуулаагүй төхөөрөмж ашигласан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6. Тусгай зөвшөөрөл, эсхүл эрхийн бичиг эзэмшигч эрхээ хэрэгжүүлэхэд хууль бусаар саад учруулсан бол хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Иймд үүрэн холбооны сүлжээний чанар муу тохиолдолд иргэн, хуулийн этгээд нь тухайн үүрэн холбооны үйлчилгээ үзүүлж буй компанидаа хандан сүлжээний чанар сайжруулах хүсэлтээ гаргах, тохирлын баталгаатай сүлжээ өсгөгч төхөөрөмж ашиглахыг зөвлөж байна.

Хаяг: Метро бизнес төв А-блок 5 давхар Д.Сүхбаатарын гудамж-13 Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201-0033,  
Утасны дугаар: 11-304258, 1800-1858, Веб хуудас: [www.crc.gov.mn](http://www.crc.gov.mn), Цахим шуудан: [info@crc.gov.mn](mailto:info@crc.gov.mn)

**Хоёр: Томилолтын тайлан, газар дээрх хяналт хэмжилт:**

ХХЗХ-ны РДӨНХТ-ийн инженерүүд Монгол Улсын 13 аймаг, 20 сум, 3 боомтын нутаг дэвсгэрт нийт 33 хоног ажиллаж, 12,105 км замыг туулж дараах хэмжилт, хяналтыг хийж зохицуулалтын арга хэмжээг авч ажилласан.

№	Хугацаа	Тушаалын дугаар	Хамрагдсан бүс нутаг	Гүйцэтгэсэн ажил
1.	2026.01.05-01.11	A/311	Баянхонгор аймаг, Ховд аймаг, Ховд аймгийн Буянт сум, Мөнххайрхан сум	Скайтел ХХК, Мобиком Корпораци ХХК, Юнител ХХК-иудын албан бичгүүдийн хүрээнд 2 байршилд ЦСО-ны хэмжилт, 2 байршилд харилцан нөлөөллийн эх үүсвэрийг тогтоох хэмжилтийг хийж, 2 ширхэг баталгаажуулаагүй үүрэн холбооны сүлжээ өсгөгч төхөөрөмж унтрааж, буулгасан.
2.	2026.02.24-03.02	A/45	Өвөрхангай аймгийн Хархорин сум, Архангай аймгийн Эрдэнэбулган сум, Их тамир сум, Завхан аймгийн Улиастай хот, Түдэвтэй сум, Сонгино сум	Скайтел ХХК болон Юнител ХХК-ийн албан бичгүүдийн хүрээнд 1 байршилд ЦСО-ны хэмжилт, 4 байршилд харилцан нөлөөллийн эх үүсвэрийг тогтоох хэмжилт, хяналтыг хийж 1 ширхэг баталгаажуулаагүй үүрэн холбооны сүлжээ өсгөгч төхөөрөмж унтрааж, буулгасан.
3.	2026.03.03	A/50	Төв аймгийн Заамар сумын Хайлааст баг	Мобиком Корпораци ХХК-ийн албан тоот хүсэлтийн дагуу байршилд ЦСО-ны хэмжилт хийсэн.
4.	2026.03.10-03.13	A/55	Багахангай дүүрэг, Багануур дүүрэг, Налайх дүүрэг, Гачуурт, Биокомбинат, 61-ийн гарам, Партизан	Олон суваг дамжуулах үйлчилгээ тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн ашиглаж байгаа нэвтрүүлэх хэсгийн тоног төхөөрөмж болон нэвтрүүлэгч болон дахин дамжуулах станцуудын радио давтамжийн зурвасыг тодорхойлж, тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн биелэлтийг хангаж байгаа эсэхийг тогтоох хэмжилт, хяналтыг хийж гүйцэтгэсэн.
5.	2026.03.10-03.15	A/56	Дорноговь аймгийн Ханги боомт, Өмнөговь аймгийн Ханбогд сум, Гашуунсухайт боомт, Даланзадгад сум, Гурван тэс сум,	Юнител ХХК-ийн албан тоот хүсэлтийн дагуу харилцан нөлөөллийн эх үүсвэрийг тогтоох хэмжилт хийж, холбогдох арга хэмжээг авсан. Ханги, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад радио давтамжийн зурваст хяналтын хэмжилт хийж гүйцэтгэсэн.

			Шивээхүрэн боомт, Дундговь аймаг	
6.	2026.03.26-04.03	A/66	Дархан-Уул аймгийн Дархан сум, Орхон аймгийн Баян-Өндөр сум, Булган аймгийн Булган сум, Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл, Мөрөн сум	Скайтел ХХК, Мобиком Корпораци ХХК, Гранд Як ХХК-иудын албан бичгүүдийн хүрээнд 10 байршилд харилцан нөлөөллийн эх үүсвэрийг тогтоох хэмжилтийг хийж холбогдох арга хэмжээг авсан.
<b>Бүх томилолтын явцад аймгийн төвүүдэд 30 МГц-6 ГГц зурвасын хэмжилтүүдийг хийж гүйцэтгэсэн.</b>				

### **Гурав. Итгэмжлэлийн магадлах үнэлгээ**

РДӨНХТ дээр 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Үндэсний итгэмжлэлийн төвийн магадлах үнэлгээ амжилттай хийгдсэн.

- MNS ISO/IEC 17020:2013 “Хяналтын ажил эрхэлдэг төрөл бүрийн байгууллагын ажиллагаанд тавих шаардлага стандарт, Үндэсний итгэмжлэлийн төвийн бодлогын баримт бичиг, холбогдох итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтэд үргэлжлэн нийцэж байгаа эсэхэд магадлах үнэлгээг Үндэсний итгэмжлэлийн төвөөс томилогдсон үнэлгээний мэргэжилтэн С.Гандөл, Ц.Очирхүү нар хийж гүйцэтгэсэн.
- Үндэсний итгэмжлэлийн төвийн магадлах үнэлгээний ажлын хэсгээс РДӨНХТ-ийг стандартын шаардлагыг бүрэн хангасан, үйл ажиллагаанд үл тохирол илрээгүй гэж дүгнэсэн.



### **Дөрөв. Олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа:**

1-р улирлын хугацаанд радио долгионы зохистой хэрэглээг төлөвшүүлэх, холбогдох хууль, дүрэм журмыг сурталчлах чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулсан.

1. “Инженер Геодези” ХХК-иас 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан **"DJI WORKSHOP 2026"** арга хэмжээнд РДӨНХТ-ийн Хөдөлгөөнт хяналтын ахлах инженер А.Алтанхуяг оролцов. Тус арга хэмжээний үеэр "Радио долгионы хэрэглээ, хяналт, харилцан нөлөөлөл болон хууль бус хэрэглээ" сэдвээр илтгэл танилцуулж, оролцогчдод радио давтамжийн тусгай зөвшөөрөл болон эрхийн бичиг авах үйл ажиллагааны дараалал, анхаарах асуудлуудын талаарх гарын авлага, зааварчилгааг түгээж ажиллалаа. Энэхүү хэлэлцүүлэгт барилга, уул уурхай, байгаль орчны мониторинг, нийтийн аюулгүй байдал, авто зам, хот төлөвлөлт болон хөдөө аж ахуйн салбарын төрийн болон хувийн хэвшлийн 30 орчим байгууллагын 100 гаруй төлөөлөл хамрагдаж, салбарын мэдээлэл солилцсон үр дүнтэй ажил болсон.



2. Хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Тээврийн цагдаагийн албаны радио холбоо хариуцсан албан хаагчдад сургалт зохион байгууллаа. Тус сургалтыг РДӨНХТ-ийн Ерөнхий инженер М.Болдбат, Хөдөлгөөнт хяналтын ахлах инженер А.Алтанхуяг нар удирдан явуулж, Радио долгионы тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журам, техникийн нөхцөл шаардлага, хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл танилцуулав. Уулзалтын төгсгөлд хоёр байгууллагын төлөөллүүд 2026 оны төлөвлөгөөт ажлуудыг харилцан уялдаатай хэрэгжүүлэх, хяналт шалгалтын чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцож, цаашдын чиглэлээ тодорхойллоо.



3. ШУТИС-МХТС-иас ирүүлсэн 1/056 тоот албан хүсэлтийн дагуу тус сургуулийн “Утасгүй холбоо” хөтөлбөрийн 3-р дамжааны 34 оюутныг РДӨНХТ-д хүлээн авч танилцах дадлагыг зохион байгуулж ажиллав. Уг арга хэмжээний хүрээнд РДӨНХТ-ийн үйл ажиллагаа, хяналтын төвд хийгддэг радио давтамжийн хэмжилт, хяналтын төрлүүд, хэмжилтийн үр дүнг боловсруулах аргачлалын талаар мэдээлэл өгөв. Мөн радио давтамжийн хэмжилтийн орчин үеийн тоног төхөөрөмжүүдийг танилцуулж, радио долгионы харилцан нөлөөллийн практик туршлагаас хуваалцлаа.

